



## Төлөвлөгөө

- Хөрс хуулалт 10,4 сая.м3
- Нүүрс олборлолт 2,0 сая.тн
- Борлуулалт 93,1 тэрбум төгрөг
- Нийт зардал 78,3 тэрбум төгрөг
- Цэвэр ашиг 13,7 тэрбум төгрөг

## Гүйцэтгэл



- Хөрс хуулалт 3,5 сая.м3
- Нүүр солборлолт 0,75 сая.тн
- Борлуулалт 25,3 тэрбум төгрөг
- Нийт зардал 22,7 тэрбум төгрөг
- Цэвэр ашиг 0,57 тэрбум төгрөг

## Биелэлт

- Хөрс хуулалт 34.2%
- Нүүрс олборлолт 37,9%
- Борлуулалт 27,2 %


## ХӨРС ХУУЛАЛТ, 0,7%-ИАР ИЛҮҮ

## НҮҮРС БОРЛУУЛАЛТ, 24%-ИАР ИЛҮҮ







2014 онд БНХАУ-ын импорт 62 сая тоннд хүрсэн. Монгол улс 24%-ийг буюу 14,8 сая тонн болсон. 2015 онд БНХАУ-ын импорт өмнөх оноос 30 орчим хувиар буурч 50,0 сая тонн болсон. 2015 онд Монгол Улсын экспорт мөн 30 орчим хувиар буурч 14,4 сая тонн болсон байна. Компанийн хувьд 5%-ийг дангаараа гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.



## Нийт 6,7 тэрбум төгрөг





Хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн 11 ажлаас 10 ажил нь Худалдан авах ажиллагааны дагуу хийгдсэн байна.

Гаалийн хяналтын бүсийг батлагдсан төсөвт өртгийн дагуу шинээр байгуулан ашиглалтанд хүлээлгэн өгч холбогдох бичиг баримтыг ГЕГазар, Гашуун сухайт дахь гаалийн газар, Тавантолгой дахь гаалийн салбарт хүргүүлээд байна.

Одоогийн байдлаар Гаалийн хяналтын бүсээр дуудлагын төлбөрт үйлчилгээгээр гаалийн ажил хийгдэж байна.

# Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн талаар:



Хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм, журмыг үндсэн зорилго болгон аюулгүй ажиллагааг эрхэмлэн ажиллаж үйлдвэрлэлийн осолгүй жил байж хөдөлмөрийн чадвар алдалт, осол гэмтэлгүй байхыг эрмэлзэж байна. Нийт ХАБЭА зардалд 210 сая төгрөг зарцуулсан.



Аюулгүй ажиллагааны сургагч багшийг Модуль 1,2-д сургаж бэлтгэн хөдөлмөрийн аюулгүй ажилаагаа, зааварчилгааны сургалтанд нийт ажилчдыг хамруулан, туслан гүйцэтгэгч компанийн ажилчид, инженерүүдэд зааварчилгааг өгч хяналт тавин сургалтанд хамруулсан.

Ажилчдын эрүүл мэндэд чиглэсэн үзлэг оношилгоог Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй тогтмол хамтран ажиллаж жилд 1 удаа үнэ төлбөргүй хамрагдуулж ажиллаа. Шаардлагатай ажилчдыг нөхөн сэргээх рашаан сувилалд хөнгөлөлттэй үнээр амраав. Ажилчдын хөдөлгөөн идэвхи нэмэгдүүлэхээр фитнес төвийг ашиглалтанд оруулав.





- Дархан цаазат ан амьтан хамгаалах, тоо толгойг тоолох ажлын хүрээнд малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиглалт хийж байна.
- Үрсэлгээ нөхөн сэргээлтийн зорилгоор хүлэмж ашиглан ажиллаж байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд төлөвлөгөө ажлыг хийж гүйцэтгэн тайлангаа олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллаж ирлээ.





Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчидээ,

Бид бүхэн хагас зуун жилийг ардаа үдэж зах зээлийн олон үе шатыг амжилттай даван туулж дэвшин хөгжсөөр өнөөдрийн энэ түвшинд ирсэн билээ. Энэ цаг хугацаанд бидэнтэй хамт байх хөгжлийг жолоог атгалцан бодлого шийдвэрийг гаргалцаж, бидэнд ажиллах урам зориг, итгэл найдвар бэлэглэдэг өмчийн эзэд та бүхэндээ түүхт 50 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлэе.